

**Монгол, солонгос хэлний туслах үйл үгийн баймж утга**Даваажавын УРТНАСАН<sup>1</sup>Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академи,  
Хэл зохиолын хүрээлэн, Харьцуулсан хэл шинжлэлийн салбар**Submitted:** September 25, 2025 | **Accepted:** November 15, 2025

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд туслах үйл үгийн баймж утгыг монгол, солонгос хэлний хүрээнд зэрэгцүүлэн авч үзнэ. Судалгаанд монгол хэлний -аад<sup>4</sup>/-ж,ч үзэх, -аад<sup>4</sup>/-ж,ч өгөх, солонгос хэлний -*아/야 보다* (-eo/a boda), -*아/야 주다* (-eo/a juda) зэрэг туслах үйл үгсийг хамруулав. Эдгээр туслах үйл үг нь байдлын утгыг илэрхийлэхээс гадна зарим тохиолдолд байдлын утгатай шууд холбоогүй, өөр төрлийн утга илрүүлдэг байна. Туслах үйл үгийн баймж утга нь өгүүлэгчийн тухайн үйл явдалд хандаж буй байр суурь, хандлагатай нягт холбоотой бөгөөд зөвхөн гол үйл үгтэй холбогдсон бүтцийн хүрээнд тодорхойлогддог. Иймээс туслах үйл үгийн баймж утгыг тодорхойлох зорилгоор дээрх хоёр хэлний жишээг зэрэгцүүлэн шинжилсний дүнд баймж утга нь өгүүлэгдэхүүн төвтэй болон өгүүлэгч төвтэй гэсэн хоёр төрөлд хуваагддаг болохыг онцлон авч үзэв.

Тухайлбал, монгол, солонгос хэлний 'үзэх' туслах үйл үг оролцсон үгийн бүтцэд "оролдох, хийхийг завдах" гэсэн баймж утга илэрч байгаа нь киргиз, япон зэрэг бусад хэлэнд мөн ажиглагддаг бөгөөд энэ нь олон хэлний нийтлэг шинж болохыг харуулж байна. Туслах үйл үг нь өгүүлэгдэхүүний үйл хөдлөлийг илтгэх оролдох, зүтгэх, дэмжих, тэтгэх, онцлох зэрэг баймж утгыг илэрхийлэх үүрэгтэйгээс гадна ихэнх тохиолдолд илүү хийсвэржиж, өгүүлэгч төвтэй баймж утга илэрхийлэх хандлагатай байдаг.

**Түлхүүр үг:** үйл үг, туслах үйл үг, үгийн сангийн утга, баймж, өгүүлэгч төвтэй баймж, өгүүлэгдэхүүн төвтэй баймж

**On Modality of Auxiliary Verbs in Mongolian and Korean**<sup>1</sup>© Д.Уртнасан, 2025Email: [urtnasand@mas.ac.mn](mailto:urtnasand@mas.ac.mn),<https://orcid.org/0009-0002-8685-8464>

**Abstract:** *The present study examines the modal meanings of auxiliary verbs through a contrastive analysis of Mongolian and Korean. The study focuses on auxiliary verb constructions such as -aad<sup>4</sup>/-j,ch üzekh and -aad<sup>4</sup>/-j,ch ögökh in Mongolian, and -eo/a boda and -eo/a juda in Korean. These auxiliary verbs express not only aspectual meanings but also meanings that are not directly related to aspect. The modal meaning of auxiliary verbs is closely associated with the speaker's stance and attitude toward the event, and it can be identified only through the structural relationship between the auxiliary verb and the main verb. In order to clarify the modal meanings of auxiliary verbs, examples from the two languages were analyzed contrastively. The results show that modal meanings can be categorized into subject-oriented and speaker-oriented types.*

*For instance, constructions involving the auxiliary verb 'see/try' in both languages convey modal meanings such as "attempt" or "trying to do" a feature that is also observed in other languages such as Kyrgyz and Japanese, indicating a cross-linguistically common phenomenon. Auxiliary verbs function not only to express modal meanings related to the subject's action such as attempt, effort, support, encouragement, and emphasis but also tend to become increasingly abstract, most often developing speaker-oriented modal meanings.*

**Keywords:** *verb, auxiliary verb, lexical meaning, modality, speaker-oriented modality, subject-oriented modality*

## 1. Удиртгал

Хэл шинжлэл дэх баймж<sup>2</sup>-ийн ай хэмээх ухагдахууныг цагийн болон байдлын ай шиг тодорхой нэгж болгон бүтээвэр, өгүүлбэр зүйн талаас задлахад ихээхэн төвөгтэй хэл зүйн хэлбэр гэж хэлэхэд нэг их ташаарахгүй. Гэсэн ч баймжийн тухай олон тооны судалгаа гарсаар ирсэн. Сүүлийн үеийн хамаарагдах судалгаануудын ихэнх нь баймжийн айг утгын талаас нь авч үзсэн байдаг. Түүнчлэн 1980-аад оны сүүл үеэс баймжийн судалгаа идэвхжиж утга судлал, хэв шинжийн зэрэг өөр онолын хавсарсан судалгааг шаардах болсон. Энэ талаас авч үзвэл монгол, солонгос хэлний баймжийн зэрэгцүүлсэн судалгаа нь зайлшгүй чухал юм. Монгол хэл шинжлэлд эрдэмтэн Ю.Мөнх-Амгалан “Орчин цагийн монгол хэлний баймжийн ай” (1998) хэмээх нэг сэдэвт бүтээл туурвиж, монгол хэлний баймжийн айг анхлан өргөн хэмжээнд авч үзэн, утгын түвшнийг

---

<sup>2</sup> Англи хэлний “modality” буюу орос хэлний “модальность” хэмээх үгийг монгол хэлэнд буулгахдаа ‘баймж чанар’ гэж оноосон байна (“Нэр томьёоны цуврал бичиг”-хэлний шинжлэл. Уб., 1974: 74). Солонгос хэлний хувьд Америкийн түгээмэл хэл шинжлэл, Европын бүтэц хэл шинжлэлд хэрэглэж ирсэн ‘modality’ буюу баймж гэх нэр томьёог авч хэрэглэн тусгай онол арга зүйг нь дагасан байна (Баг Жинь Ху, 2013: 309).

нь төвийн болон захын тогтолцоонд ялган ойлгож, утгыг мэдэгдэхүүн ба мэдэхүүн, хэл ба хэлэхүйн талаас хоёрчлон ангилсан байдаг. Тус бүтээлдээ монгол хэлний баймжийн утгын хүрээг “баймжийн айн утга зүйн багтаамж” нэрийн дор төгсгөх нөхцөлийн хүрээнд тооцоолон гаргаж, нийт 129 утгыг тодорхойлжээ. Ингэхдээ өгүүлбэр зүйн хэрэглүүрүүдэд тулгуурласан байдаг. Мөн Ц.Өнөрбаян “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн баймж чанар ба зарим чимэх үгийн утга байр” (1996) өгүүлэлдээ асуух, мэдээлэх, хандах өгүүлбэрт илрэх баймжийн утгыг нарийвчлан авч үзсэн. Харин монгол хэлний баймжийн айн тухай хэлний хэв шинжийн судалгаа ховор бөгөөд урьд гарсан судалгаанууд дан ганц бүтээвэр зүйн судалгаа байдаг. Солонгос хэлний баймжийн тухайд мөн адил бүтээвэр зүйн талын судалгаа голлодог ч сүүлийн үед хэв шинжийн талаас судлах болжээ.

## 2. Судалгааны арга зүй

Хэл тус бүрийн туслах үйл үгийн утга, үүрэг янз бүр байдаг. Тус өгүүлэлд монгол, солонгос хэлний зарим туслах үйл үгэнд дүн шинжилгээ хийж, үр дүнд нь хэлний баймж утгын хэл зүйн үүргийг тодруулах юм. Хамгийн гол зүйл нь хоёр хэлний тохиолдолд туслах үйл үгийн утга нь ерөнхий хэл шинжлэл дэх байдал, баймжийн тухай ерөнхий ойлголтоос гадна тусгай тогтолцоог агуулж байгаад оршино. Туслах үйл үг нь үгийн сангийн нэгж бөгөөд үндсэн үйл үгээр хэрэглэгдэхдээ үгийн сангийн утгаараа байдаг бол туслах үйл үгээр хэрэглэгдэхдээ утга нь хийсвэржиж, хэл зүйн тогтсон үүрэгтэй болдог. Тус судалгаанд туслах үйл үгийн үгийн сангийн ангилал ба хэл зүйн ангиллыг тусад нь ялгаж байдлын бус утга илэрхийлж буй туслах үйл үгийг авч үзнэ.

Ингэснээр хоёр хэлний туслах үйл үгийн хэлзүйн утга болон хэлзүйжилтийн хэв шинжийг зохих жишээгээр тодруулан, хэл тус бүрийн туслах үйл үгт агуулагдах баймж утгын онцлогийг илрүүлэх юм.

Тус судалгааны арга нь хэлний хэв шинж (linguistic typology)-д хамаарах ба тухайн хэлнүүдийн онцлогийг тодруулахдаа хэлний зэрэгцүүлэл (contrastive analysis)-ийг ашиглана.

## 3. Туслах үйл үг

Үгийн сангийн бие даасан утгаа алдаж, хам бүтцийнхээ хүрээнд голлож байгаа үйл үгийнхээ хэл зүйн утгыг илтгэж, задлаг хам бүтэц үүсгэдэг үйл үгийг туслах үйл үг гэдэг. (Ц.Өнөрбаян, 2022: 165).

Монгол, солонгос хэлэнд цөөн хэдэн холбох нөхцөл туслах үйл үгийн бүтцэд<sup>3</sup> хэрэглэгддэг. Үүнд: монгол хэлний ‘-ж/ч, -аад<sup>4</sup>, -н, -саар<sup>4</sup>’, солонгос хэлний ‘-eo/a (-ᄂᆞᆫ/ᄂᆞᆫ), -go (-ᄂᆞᆫ), -ji (-ᄂᆞᆫ), -ge (-ᄂᆞᆫ)’ зэрэг нөхцөл хамаарна. Үүнээс, монгол хэлний ‘-ж/ч, -аад<sup>4</sup>’, тэдгээртэй ижил утгатай солонгос хэлний ‘-go, -eo’ холбох нөхцөлүүд туслах үйл үгийн бүтцэд хамгийн өргөн хэрэглэгддэг байна. Монгол хэлний ‘-ж/ч, -аад<sup>4</sup>’ -н, нөхцөлийн тухайд эл өгүүллийн зохиогчийн бичсэн, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Altaica XIX” эрдэм

<sup>3</sup> Туслах үйл үгийн бүтцийг монгол хэл шинжлэлд нийлмэл өгүүлэхүүн, үйл үгийн задлаг хам бүтэц гэх мэтээр томъёолж иржээ.

шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн “Монгол, солонгос хэлний үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөлийн хэв шинж” өгүүлэлд хэлний хэв шинж дэх үнэмлэхүй бус нийтлэгийг хэлний дотоод талыг тайлбарлах арга зүйгээр ‘үйлийн туслан холбох нөхцөл’ гэж тодорхойлоод, туслах үйл үгтэй задлаг хам хэлбэрээр нийлэмж бүтээдэг онцлогийг мөн монгол, солонгос хэлний жишээгээр тайлбарласан байдаг (2023: 143). Эдгээр холбох нөхцөл нь ихэнх тохиолдолд дангаараа бус туслах үйл үгтэй холбогдож тодорхой утгыг илэрхийлдэг. Гэхдээ солонгос хэлний *-eo/a yeo* (-어/아 여) (шийдвэрлэх буюу үүрэг заах), *-ullae* (-올래) (зорилго, санаа илэрхийлэх), *-goja* (-고자) (зорилго илэрхийлэх) зэрэг холбох нөхцөл нь туслах үйл үгээс хамааралгүйгээр өөрийн гэсэн утгыг илэрхийлдэг байна. Үүнтэй адил монгол хэлний ‘*-саар*<sup>4</sup>’ нөхцөл бие даасан утгаар хэрэглэгддэг. Монгол хэлний туслах үйл үгийн бүтцэд цаг нь зөвхөн туслах үйл үг дээр илэрдэг. Энэ нь солонгос хэлэнд мөн адил байдаг ч *-eo/a yeo* болон *-eumyeon* (-으면/-면) зэрэг нөхцөлүүд нь цагаар төгсгөсөн үйл үгэнд холбогдож болдог онцлогтой.

### 3.1. Монгол хэлний туслах үйл үгийн хэв шинж

Монголч эрдэмтэн З.К.Касьяненко бие даасан үйл үгийг баймж үйл үгтэй холбох нийлэг буюу үг зүйн арга байдаг гэж үзээд түгээмэл хэрэглэгддэг үйл үгийн жишээнд нь *чадах, ядах, болох, болохгүй, үзэх, мэдэх, зохих, санагдах, бодогдох, үзэгдэх* зэрэг үйл үгийг хамааруулсан байдаг (Ю.Мөнх-Амгалан, 1998: 39). Энд харагдаж буй хүснэгт 1-д монгол хэлний хэрэглээний өндөр давтамжтай 17 туслах үйл үгийн задлаг хам бүтцийг харуулж байна.

*Хүснэгт 1. Монгол хэлний туслах үйл үгийн жагсаалт*

Холбох нөхцөл	Туслах үйл үг
<i>-жс, -аад<sup>4</sup>, -н</i>	<i>өг-</i>
	<i>од-</i>
	<i>үз-</i>
	<i>гар-</i>
	<i>алд-</i>
	<i>мэд-</i>
	<i>таар-</i>
	<i>орхи-</i>
	<i>хэвт-</i>
	<i>ав-</i>
	<i>суу-</i>
	<i>тар-</i>
	<i>оч-</i>
	<i>хая-</i>
	<i>яв-</i>
	<i>ир-</i>
	<i>ор-</i>

“Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт” хэмээх бүтээлд “... жинхэнэ” үйл үгийн дотроос гол үгэндээ тусалж үгийн сангийн утга нь ямар нэг хэмжээгээр сулран хэрэглэгдсэн олон үг байдгийг үгүйсгэх үндэсгүй, ...тэдгээр туслах үйл үгийн дотроос ‘бай-, бол-’ хоёр өвөрмөц бөгөөд их хэрэгцээтэй, агуулга үүрэг нь маш нарийн (1987: 175,177) гэж дурдсан байдаг. Мөн “Орчин цагийн монгол хэл” хэмээх бүтээлд “Ерөнхийдөө ганц үгээр бүтсэн өгүүлэхүүнийг энгийн өгүүлэхүүн, хоёр буюу түүнээс дээш өгүүлэхүүнээр бүтсэн өгүүлэхүүнийг нийлмэл өгүүлэхүүн гэнэ. Нийлмэл өгүүлэхүүнд их төлөв нэг үг голлож, нөгөө үг нь туслах чанартай орсон байдаг. Нийлмэл өгүүлэхүүний бүтэц нь нэр үг + туслах үйл үг, үйл үг + туслах үйл үг” гэсэн үндсэн хэв маягтай. ...үйл үг туслах үйл үг бүтэцтэй нийлмэл өгүүлэхүүн нь төгсгөлийн, төгсгөлийн бус өгүүлэхүүн байж болно. Энэ хэв маягийн нийлмэл өгүүлэхүүний голлох үйл өгүүлэхүүн нь үйл үгийн зэрэгцүүлэн холбох *-ж/ч, -аад<sup>4</sup>*, хааяа *-н*, нөхцөлдүүлэн холбох *-саар<sup>4</sup>*... тодосгон холбох нөхцөлөөр хэлбэржиж, араас нь *бай-, бол-* зэрэг туслах үйл үг орж бүтнэ” хэмээн дурдсан байдаг (2008: 235, 236). Энэхүү эшлэлд дурдсан “нийлмэл өгүүлэхүүн” хэмээх нэр томьёо нь туслах үйл үгийн задлаг хам бүтцийг илэрхийлэх нэр томьёо болохоос биш өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүний шинжийг илтгэхгүй юм. Харин “Altaica XII” эрдэм шинжилгээний сэтгүүл (2015) дэх “Монгол, солонгос хэлний холбоц үгийн хэв шинж” хэмээх өгүүлэлд ‘бай-, бол-’ үйл үгийг эл өгүүллийн зохиогч ‘холбоц үг (copula)’ гэж үзсэн тул энд туслах үйл үгээр тооцож өгүүлсэнгүйг тэмдэглэх хэрэгтэй.

### 3.2. Солонгос хэлний туслах үйл үгийн хэв шинж

Солонгос хэлний туслах үйл үгийн ангиллын талаар судлаачид нэгдсэн саналд хүрээгүй байдаг нь тэдгээрийн хэлзүйн олон талт шинжтэй холбоотой. Нэг шинжийг баримтлахад зарим туслах үйл үг хасагдах, харин утгын хүрээг өргөжүүлэхэд ангиллын нарийвчлал алдагдах асуудал гардаг. Иймээс ихэнх судлаач туслах үйл үгийг өгүүлбэр зүйн онцлогоор нь ангилан, хэлбэр бүрийн утгыг тогтолцоотой тайлбарлахыг зорьсон байдаг. Эдгээрээс туслах үйл үгийг гол үгтэй холбож буй үйлийн холбох нөхцөлөөр нь ангилж ‘-ㅅ/ㅁ’ (-eo/-a) нөхцөлөөр эхэлсэн 11 туслах үйл үг, ‘-고’ (-go) нөхцөлөөр эхэлсэн 2 үйл үгийг оруулж тооцсон жагсаалтыг энд дагав (Бэг Бун Жа, 2004: 451). Хүснэгт 2 нь хэрэглээний өндөр давтамжтай солонгос хэлний туслах үйл үгийн задлаг хам бүтцийг харуулж байна.

Хүснэгт 2. Солонгос хэлний туслах үйл үгийн жагсаалт

Холбох нөхцөл	Туслах үйл үг
	보다 (үзэх)
	오다 (ирэх)

-어/아	놓다 (орхих) 가다 (явах) 내다 (зарах) 대다 (байх) 버리다 (хаях) 주다 (өгөх) 지다 (болох) 두다 (байлгах) 드리다 (өгөх)
-고	있다 (байх) 싶다 (-маар байна)

Энэхүү жагсаалтад ороогүй үгс нь гол үйл үгэнд залгагдаж ‘V+үйлийн холбох нөхцөл Vaux’ бүтцийг харуулах ч өгүүлбэр зүй, утга зүйн талаас гол үйл үгийн шинжийг хадгалахаас туслах үйл үгийн “утга түшсэн” шинж илэрхийлдэггүй онцлогтой.

#### 4. Туслах үйл үгийн баймж утга

Ерөнхий хэл шинжлэлд 1950-аад оноос эхэлж англи хэл дээр тулгуурласан баймжийн тухай судалгаанууд гарч эхэлжээ.<sup>4</sup> Баймж гэдэг нь өгүүлэгчийн сэтгэл зүйн байр байдал өгүүлбэрт ямар нэг хэл зүйн хэлбэрээр илрэх зүйл юм. Өгүүлэгчийн сэтгэл зүйн байр байдал, хандлага илэрхийлэх аргад үгийн язгуурт залгах бүтээврийн аргаас гадна дайвар үг, тэмдэг нэрээр илрүүлэх зэрэг үгийн сангийн арга, мөн аялга, акцентын зэрэг авиа зүйн арга, түүнчлэн өгүүлбэр зүйн олон янзын арга бий. Байби нар (1994)-д өгүүлэгч төвтэй баймж (speaker-oriented modality), өгүүлэгдэхүүн төвтэй баймж (subject-oriented modality) гэх ойлголтыг гаргасан. Уламжлалт ойлголтоор өгүүлэгч төвтэй баймж нь өгүүлэгчийн ‘баталж, нотолсон’ зэрэг сэтгэл зүйн байдлыг, харин өгүүлэгдэхүүн төвтэй баймж нь үйлийн эзний (өгүүлэгдэхүүний) үйл хөдөлгөөнтэй холбоотой ‘хүсэл, зорилго, идэвх, хариуцлага’-ын утгыг илэрхийлж байна.

Баймжийн ерөнхий тогтолцоог дараах байдлаар авч үзсэн байдаг (Баг Жинь Ху, 2013: 310-311).

- а. Танин мэдэхүйн баймж (epistemic modality)-өгүүлэмжийн баттай эсэхийг ухаарах, итгэсэн байдлыг илэрхийлэх

<sup>4</sup> “Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт” (1987) -д “Хэлний баймж чанарын категорийн тухай онолын ерөнхий үндсийг Зөвлөлтийн эрдэмтэн академич В.С.Виноградов боловсруулсан ба түүний ‘өгүүлж байгаа зүйлээрээ дамжуулан бодит байдалд харьцах өгүүлэгч этгээдийн тогтоосон харьцааг баймж чанарын категори гэнэ’ (Грамматика русского языка” Том II, синтаксис, 1960: 80) хэмээн авч үзсэнийг нь баймж чанарын тухай судлахад онолын гол үндэслэл болгодог тухай өгүүлээд, мөн тэнд “Монгол хэлэнд баймж харьцааг хэрхэн илрүүлэх талаар судалгаа маш ховор байна. Орчин цагийн монгол хэлэнд баймж утгыг үг зүй, өгүүлбэр зүй, үгийн сан, аялгын аргаар илрүүлдэг” (1987: 139) хэмээсэн байдаг.

- б. Ёс зүйн баймж (deontic modality)-нөхцөл байдал дахь эрх үүрэг, хариуцлага, зөвшилцлийг илэрхийлэх
- в. Хөдөлгөөнт баймж (dynamic modality)-нөхцөл байдлын шалтгаан болох чадавх, зорилго, хүслийг илэрхийлэх
- г. Сэтгэл хөдлөл, үнэлэмжийн баймж (emotive/evaluative modality)-гайхах, айх, гуниглах зэрэг өгүүлэгчийн сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлэх
- д. Нотлох баймж (evidential modality)-мэдээллийн эх сурвалж, туршлага, эргэцүүлэлтэй холбоотой баталгааг илэрхийлэх гэх мэт.

Энд туслах үйл үгийг байдлын<sup>5</sup> болон баймжийн утга илэрхийлдэг гэж хуваан үзэж, баймжийн утга илэрхийлэх хэсэгт төвлөрч буй билээ. Өгүүлэгдэхүүн төвтэй баймж (үйлийн эзний~) нь үгийн сангийн нэгж хэл зүйн баймжийн нэгж рүү шилжиж буй хэлзүйжих үзэгдэлд буй ухагдахуун ажээ. Учир нь туслах үйл үгээр илрэх ‘дэмжих, оролдох, гүйцэтгэх, зүтгэх’ зэрэг утга нь үйлийн эзний тухай өгүүлэгчийн сэтгэл зүйн үнэлэлт дүгнэлтийг илэрхийлэх боломжтой баймж гэж үзэх магадлалтай. Үүнээс зөвхөн туслах үйл үгийн баймж утгыг авч үзвэл дараах байдалтай байна.

- Туршилтын буюу оролдлогын баймж (attemptive modality)
- Өгөөж тусын буюу дэмжлэгийн баймж (benefactive modality)
- Магадлал, болзошгүйн баймж (probability modality)
- Зөвшөөрөх буюу боломжийн баймж (permission modality) гэх мэт.

Эдгээрээс эхний баймж утгыг өгүүлэгдэхүүн төвтэй, удаах гурван баймжийг өгүүлэгч төвтэй гэж үздэг байна.

Монгол хэл шинжлэлд баймж утгыг өгүүлэхүүнийхээ төгсгөлд байрласан (*‘Хэнийг их санаснаас бэтэгтэй болдог гэдэг худал юм шив дээ’*), өгүүлэхүүнийхээ өмнө байрласан (*‘Түүний хэлснийг би эс ойлгов’*), өгүүлэхүүнийхээ голлосон ба туслах хэсгийн дундуур орж байрласан (*‘Тэднийх нүүж байгаа юм байх’*) (ОЦМХ, 2008: 237) гэх мэтээр өгүүлэхүүн буюу үйл үгээс нь ямагт салган авч үзсэн байдаг бөгөөд харин туслах үгэнд агуулагдах өгүүлэгч, өгүүлэхүүн төвтэй баймжийн тухай авч үзээгүй юм. Тиймээс туслах үгийн баймж утгыг авч үзвэл дараах байдалтай байна.

Монгол хэлний туслах үйл үгийн ‘дэмжлэг’ илэрхийлсэн баймжийг үйлдэл нь хэнд ашигтай байгаагаас шалтгаалан хоёр хувааж болдгийг V-j av-, V-j ög- туслах үйл үгээс харж болно. Үйл үг нь өгүүлэгчийн (subjects) ашигт хамаарах тохиолдолд → V-j av- (*‘V-Conn авах’*), үйл үг нь бусдын (non-subjects) ашигт хамаарах тохиолдолд → V-j ög- (*‘V-Conn өгөх’*) гэсэн эсрэг чиглэлийн утгатай хэрэглэгддэг. Харин солонгос хэлэнд туслах үйл үгийн ‘дэмжлэг’ илэрхийлсэн баймж утга нь ихэвчлэн V-eo ju- (*‘V-Conn өгөх’*) гэсэн туслах үйл үгийн бүтцээр л илэрхийлэгддэг. Ийм онцлогууд дурдаж буй хоёр хэлэнд байдаг тул туслах үйл үгийн ‘оролдлого’ болон ‘дэмжлэг’ илэрхийлсэн баймж утгыг нарийвчлан авч үзье.

<sup>5</sup> Байдлын утга илэрхийлж буй туслах үйл үгийг [+холбох нөхцөл] -тэй холбогдсон уу гэдгээр л ангилж болно. Ийм туслах үйл үгийн үгийн сангийн утга нь ижил байх эсвэл өгүүлбэрт илрэх хийсвэр утга нь ижил байдаг онцлогтой.

#### 4.1. Монгол, солонгос хэлний туслах үйл үгийн ‘оролдлого’ илэрхийлсэн баймж утга

Монгол хэлний ‘-аад<sup>4</sup>/-ж, ч үзэх’ туслах үйл үгийн утгыг ‘туршиж үзэх’, ‘туршлага хуримтлуулах’ гэх мэтээр үзэхээс гадна бичгийн хэлэнд ‘гэ-ж үзэх’ ‘ав-ч үзэх’ гэх мэт хэллэгээр илэрсэн байдаг.

- (1) а. Морь уна-ж үз-ье.  
Horse-ACC get on-Conn see-HORT  
*‘Let’s get on the horse.’*
- б. 말을 타 보-세요.  
mal-uel ta bo-seyo.  
Horse-ACC get on-Conn see-HORT  
*‘Let’s get on the horse.’*

Жишээ (1а, б) нь монгол, солонгос хэлний ‘туршиж үзэх’ утга бүхий туслах үйл үгийг адилхан харуулж буй жишээ бөгөөд солонгос хэлний ‘-어/아 보다 (-eo/a boda)’ туслах үйл үгийн үндсэн утгаас гаднах утгыг тухайн өгүүлбэрээс нь мэднэ. Өгүүлэгчийн илэрхийлэх утга өгүүлэхүүнтэйгээ зохицсон өгүүлэгдэхүүний туршлага, оролдлогыг үнэлж дүгнэсэнтэй холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл, өгүүлэгдэхүүн төвтэй баймж үйл үг нь гол үйл үгийн илэрхийлж буй үйлдлийг болон өгүүлэгдэхүүний хүсэл, оролдлого, зүтгэл зэргийг илэрхийлэх өгүүлэгчийн үнэлэлтээр илэрнэ.

- (2) а. 핸드폰 좀 끄-어 봐.  
Phone please turning off-Conn see-IMP  
*‘Гар утсаа унтраа-ж үз!’*
- б. 핸드폰 좀 끄-어.  
Phone turning off-IMP  
*‘Гар утсаа унтраа!’*

Жишээ (2) нь хоёр хэлний маш сонирхолтой ялгааг харуулж байна. Солонгос хэлний тухайд гол үйл үгэнд шууд захирах хүсэхийн төгсгөх нөхцөл шууд залгасан жишээ (2б)-ээс илүү туслах үйл үг орсон жишээ (2а) нь илүү эерүүлж, зөөлрүүлсэн утга илэрхийлж байна. Гэтэл монгол хэлэнд эсрэгээрээ гол үйл үгэнд шууд захирах хүсэхийн төгсгөх нөхцөл шууд залгасан жишээ (2б)-ээс илүү туслах үйл үг орсон жишээ (2а) нь ‘тээршаасан, шүүмжилсэн, захирсан’ хандлагыг илэрхийлсэн байна. Тэгэхлээр монгол хэлний ‘-аад<sup>4</sup>/-ж, ч үзэх’, солонгос хэлний ‘-어/아 보다 (-eo/a boda)’-тай гол үйл үгийн утга болон туслах үйл үгийн үүргээр орох нь адил ч солонгос хэлний энэхүү туслах үйл үг нь зөвхөн ‘оролдлого, туршлага’-ын өгүүлэгдэхүүн төвтэй баймж утгыг илэрхийлдгээрээ ялгаатай байна.

#### 4.2. Монгол, солонгос хэлний туслах үйл үгийн ‘дэмжлэг’ илэрхийлсэн

## баймж утга

Хэлний ‘өгөх’ үйл үг нь бусад үйл үгээс ‘үйл-дэмжлэг авагч-дэмжих’ гэсэн 3 хүчин зүйлийг шаарддагаараа ялгардаг. Энэ онцлогоороо өгөх оршихын тийн ялгалыг шаардаж хэл бүрд анхаарал татдаг гэж болно. Өөрөөр хэлбэл, шууд бус тусагдахуун буюу дэмжлэг авагчийн тийн ялгалын ноогдол ба утгын үүргийн талаар их дурдсан байдаг. Тэгвэл энэ гол үйл үгээс туслах үйл үг нь тусгай шинжийг агуулдагаараа ялгарна. Мөн цөм бүтцэд тогтсон нөлөө үзүүлдгээрээ онцлог. Гол үйл үгээс туслах үйл үг хүртэл хувьсахдаа SOV бүтэцтэй олон хэлэнд хэлний нийтлэгийг үзүүлдэг. Үйл үг үргэлжилж илэрдэг хэлнүүдэд гол үйл үгийг хамруулж ‘холимог хэрэг явдал’ (complex event) гэж ойлгон тэрхүү хэрэг явдлын сүүлийнхэд туслах үйл үг ‘өгөх үйл хэрэг’ (giving event)-ийг гүйцэтгэж байна гэж үздэг байна. Монгол хэлний ‘-аад<sup>4</sup>/-ж, ч өгөх’, солонгос хэлний туслах үйл үг ‘-어/아 주다 (-eo/a juda)’ нь баймжийн хувьд ‘дэмжлэг’-ийн утга илэрхийлдэг байна. Дараах жишээ (3а, б), (4а, б)-ээс харвал дараах байдалтай.

(3) а. Би ном унши-ж өг-ье.

I-NOM book-ACC read-Conn give-IMP

*‘I’ll read you a book.’*

б. 제가 책을 읽-어 줄-게요.

je-ga chaeg-uel ilg-eo ju-lgeyo.

I-NOM book-ACC read-Conn give-IMP

*‘I’ll read you a book.’*

(4) а. Би ном уншуул-ж ав-ья.

I-NOM book-ACC read-CAUS-Conn take-IMP

*‘I’ll have you read me a book.’*

б. 제가 책을 읽어 달라고 할게요.

Je-ga chaeg-uel ilg-eo dalla-go ha-lgeyo.

NOM book-ACC read-Conn ask-QUOT give-FUT-FIN.end

*‘I’ll ask (someone) to read me a book.’*

Жишээ (3а, б)-ээс харахад монгол, солонгос хэлний ‘униших’ гэсэн гол үйл үг нь ‘-аад<sup>4</sup>/-ж, ч өгөх’ туслах үйл үгтэй хавсран ‘дэмжих’ баймж утгыг илэрхийлж байгааг ажиглаж болно. Харин жишээ (4а), өөрөөр хэлбэл монгол хэлний “Би ном уншуул-ж ав-ья.” гэсэн өгүүлбэрт ‘-аад<sup>4</sup>/-ж, ч авах’ туслах үйл үгийн задлаг хэлбэр нь мөн ‘дэмжих’ баймж утгыг илэрхийлж байна. Гэтэл солонгос хэлний жишээ (4б)-д тухайн ижил бүтцээр тус утга илрэхгүй байна. Энэхүү ялгаа нь монгол, солонгос хэлний туслах үйл үгийн хэрэглээний онцлогийг харуулж байна.

## 5. Дүгнэлт

Энэ хүртэл монгол хэлний -аад<sup>4</sup>/-ж,ч үзэх, -аад<sup>4</sup>/-ж,ч өгөх, солонгос хэлний -어/아 보다 (-eo/a poda), -어/아 주다 (-eo/a juda) зэрэг туслах үйл үгийн баймжийн

утгыг авч үзлээ. Бүтэц хэл шинжлэлийн үүднээс баймжийг үйлийн эзний байр байдал, сэтгэл зүйг илэрхийлсэн ба сонсогчийн тухай өгүүлэгчийн байр байдлыг илэрхийлсэн гэж ангилан авч үзэж ирсэн. Харин ерөнхий хэл шинжлэлийн үүднээс өгүүлэгчийн сэтгэл зүйтэй холбоотой утга зүйн нэгж гэдгээр ухаарч үйл үгийн хэрэглээний хэлбэрээр илрэх хэл зүйн нэгжийг ‘төлөв байдал (mood)’, түүнээс гаднах хэлний илэрхийллийн хэлбэрийг ‘баймж’ гэж ялгаатай авч үзэн, үүнээс шалтгаалж баймж гэдэг нь хэлний хэлбэр биш хэлний хэлбэрт агуулагдаж буй утга гэж ойлгогдох болов. Энэхүү баймжийг үгийн сан, авиа зүй, бүтээвэр зүй, өгүүлбэр зүйн зэрэг олон янзын аргаар илэрхийлдэг.

Солонгос хэлний баймжийн тухай судалгаа нь бүтээврийн бүтэц зүйгээр өгүүлбэр дэх өгүүлэгчийн санаа бодол, үнэлэлт дүгнэлт, туршлага зэрэг мэдрэхүйн байдлын утгыг авч үзэхдээ эхлээд ихэвчлэн өгүүлбэрийн төгсгөлийн хэлбэрт төвлөрч байсан бол цаашдаа өгүүлбэр дэх бүтээврийн бүтэц, өгүүлбэрийн төгсгөлөөс гадна хэлбэрт анхаарах болсон байна. Үүний зэрэгцээ баймжийн илэрхийллийн бүтэц нь хэлзүйжиж тухайн ухагдахуун улам тэлсэн.

Үүнтэй адил монгол хэлний олон туслах үйл үгийг мөн үгийн сангийн үйл үгийн хэлзүйжилтээр бий болсон гэж үзэж болохыг энэхүү өгүүлэлд авч үзлээ. Тиймээс цаашид ч хоёр хэлний туслах үйл хэлзүйжилтэд орсоор байх магадлалтай юм. Ийм хэлзүйжилтийн үйл явц мөн монгол, солонгос хоёр хэлэнд ажиглагдаж байна.

## Ном зүй

- Баг Жинь Ху**, (2013). 박진호. 시제, 상, 양태. *국어학* 60. Цаг, байдал, баймж. *Эх хэл судлал*. 60. [Bag Jin Ho. Sije, sang, yangtae. [Tense, Aspect and Modality], *Gugeohag*.60. 2013]
- Бэг Бун Жа**, (2004). 백봉자. 한국어 문법 사전, 연세대학교 출판부. *Солонгос хэлний хэл зүйн толь*. Ёнсэ Их Сургуулийн хэвлэлийн газар. [Baeg Bong Ja. *Hangugeo munbeob sajeon* [Korean Grammar Dictionary], Yeonsedaehakkyo chulpanbu. 2004]
- Байби, Ж нар** (1994). J.Bybee, R. Perkins, & W.Pagluica *The evolution of grammar: Tense, aspect and modality in the languages of the world*, Chicago: University of Chicago press.
- Мөнх-Амгалан, Ю.** (1998). *Орчин цагийн монгол хэлний баймжийн ай*. Улаанбаатар. [Munkh-Amgalan, Yu. *Orchin tsagyn mongol khelnii baimjiin ai* [The Modality in Modern Mongolian]. Ulaanbaatar, 1998]
- Нэр томъёоны цуврал бичиг-хэлний шинжлэл.** (1974). Улаанбаатар. [*Ner tomyony tsuvral bichig-khelnii shinjlel* [Linguistic Analysis of a Terminological Series]. Ulaanbaatar, 1974]
- Орчин цагийн монгол хэл.** (2008). Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Улаанбаатар. [*Orchin tsagiin mongol khel* [The Modern Mongolian]. Mongolian National University of Education, Ulaanbaatar, 2008]
- Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт.** (1987). Улаанбаатар. [*Orchin tsagyn mongol khelnii üg züin baiguulalt* [The Morphological Structure of

the Modern Mongolian]. Ulaanbaatar, 1987]

- Өнөрбаян, Ц.** (1996). Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн баймж чанар ба зарим чимэх үгийн утга байр. *Монгол хэл шинжлэл*, дугаар 1, Улаанбаатар. [Onorbayan, Ts. Orchin tsagyn mongol khelnii ögүүлberiin baimj chanar ba zarim chimekh ügiin bair [Sentence Modality in Modern Mongolian and the Semantics and Position of Form Words]. *Mongol khel shinjlel. I*, Ulaanbaatar, 1996]
- Өнөрбаян, Ц., Жумдаан, Л., Саруул-Эрдэнэ, М., Ганбаатар, Ж.** (2022). *Үг зүй-Монгол хэл судлал IX боть*. Улаанбаатар. [Onorbayan, Ts., Jumdaan, L., Saruul-Erdene, M., Ganbaatar, J. *Üg züi-Mongol khel sudlal* [Morphology. Mongolian Language Studies -Volume IX]. Ulaanbaatar, 2022]
- Уртнасан, Д.** (2015). Монгол, солонгос хэлний холбоц үгийн хэв шинж. *Altaica XII*, Улаанбаатар. [Urtnasan, D. Mongol, solongos khelnii kholbots ügiin khev shinj [Typology of the copula in Mongolian and Korean]. *Altaica XII*, Ulaanbaatar, 2015]
- Уртнасан, Д.** (2023). Монгол, солонгос хэлний үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөлийн хэв шинж. *Altaica XIX*, Улаанбаатар. [Urtnasan, D. Mongol, solongos khelnii üiliin zeregtsüülen kholbokh nökhtsöl [Typology of Coordinating Verb Connective Suffixes in Mongolian and Korean]. *Altaica XIX*, Ulaanbaatar, 2023]

Товчилсон үг:

ACC-accusative  
CAUS-causative/benefactive marker  
Conn -connective  
HORT-hortative  
IMP-imperative  
NOM-nominative case  
QUOT-quotative marker  
FUT-future tense  
FIN.end-final ending



**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>